

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/64/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Э.Эрдэнэбат

Утас: 99352099

Цахим хаяг: tseb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № *68*

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын Соёлын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна. □

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10,000.0 мянган төгрөгийн номын сангийн фондыг баяжуулсан, Дархан-Уул аймгийн засаг даргын 01-А/314 тоот захирамжаар Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон соёлын төвийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх 25,379.2 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж нийт 35,379.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө, бараа материал бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 163,955.7 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 69.3 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Хонгор сумын Соёлын төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлэг 7 зорилтын хүрээнд 48 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 94 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,309,038.07	48,927,695.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,957,429.07	0.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	6,957,429.07	0.00
3121	төгрөг	6,957,429.07	0.00
31211	Төрийн сангийн харилцах	6,957,429.07	0.00
33	АВЛАГА	528,674.00	0.00
335	Бусад авлага	528,674.00	0.00
3351	Байгууллагаас авах авлага	528,674.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,822,935.00	48,927,695.00
354	Хангамжийн материал	34,822,935.00	48,927,695.00
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	590,700.00	590,700.00
35450	Барилгын засварын материал	466,040.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	33,766,195.00	48,336,995.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	320,774,231.80	372,154,289.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	320,774,231.80	372,154,289.93
392	Биет хөрөнгө	318,412,836.63	369,574,494.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	281,303,058.00	281,303,058.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(23,648,153.85)	(28,996,052.37)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,259,900.00	92,442,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,086,824.25)	(22,216,999.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,900,967.00	32,563,767.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,438,037.81)	(12,612,079.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,147,850.00	1,147,850.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(244,856.46)	(276,482.34)
39217	Ном	15,218,934.00	26,218,934.00
393	Биет бус хөрөнгө	2,361,395.17	2,579,794.99
39301	Программ хангамж	3,099,300.00	2,649,580.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,711,904.83)	(1,043,785.01)
39303	Бусад биет бус хөрөнгө	974,000.00	974,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	363,083,269.87	421,081,984.93
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	363,083,269.87	421,081,984.93
51	Засгийн газрын хувь оролцоо	363,083,269.87	421,081,984.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	76,624,415.82	76,624,415.82
51101	Өмч: - төрийн	76,624,415.82	76,624,415.82
512	Хуримтлагдсан үр дүн	5,841,649.64	63,840,364.70
51210	Өмнөх үеийн үр дүн	5,841,649.64	5,841,649.64
51220	Тайлант үеийн үр дүн		57,998,715.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	280,617,204.41	280,617,204.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	363,083,269.87	421,081,984.93



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	234,165,051.26	362,763,856.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,341,000.00	80,494,680.00
120	Нийтлэг татварын бус орлого	54,341,000.00	80,494,680.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,578,000.00	4,339,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,578,000.00	4,339,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	28,593,000.00	62,089,180.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	21,170,000.00	14,066,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	179,824,051.26	282,269,176.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	128,932,551.26	229,449,176.42
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	128,932,551.26	229,449,176.42
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,891,500.00	52,820,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,891,500.00	52,820,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	191,031,129.44	304,765,141.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,031,129.44	304,765,141.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	172,790,007.00	268,095,390.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,618,033.00	164,484,410.06
210101	Үндсэн цалин	71,357,825.27	102,248,589.18
210102	Нэмэгдэл	15,037,217.78	45,017,262.88
210104	Урамшуулал	11,222,989.95	17,218,558.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,756,135.89	19,659,653.20
210201	Тэтгэврийн даатгал	6,738,135.89	13,230,653.20
210202	Тэтгэмжийн даатгал	1,004,500.00	1,624,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	803,700.00	758,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	200,800.00	749,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,009,000.00	3,296,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,708,677.56	39,569,917.28
210301	Гэрэл, цахилгаан	1,030,884.56	1,051,382.28
210302	Түлш, халаалт	30,889,145.00	36,479,806.00
210303	Цэвэр, бохир ус	3,788,648.00	2,038,729.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,641,982.75	4,526,998.51
210401	Бичиг хэрэг	598,200.00	1,160,300.00
210402	Тээвэр, шатахуун	997,250.00	1,628,675.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	371,532.75	304,623.51
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	525,000.00	1,073,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,230,900.00	4,615,290.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	0.00
210604	Урсгал засвар	6,130,900.00	4,615,290.00
2107	Томилолт, зочны зардал	64,000.00	1,964,000.00
210702	Дотоод албан томилолт	64,000.00	1,964,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,975,000.00	9,049,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,275,000.00	8,719,450.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	184,402,051.26	286,608,176.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,578,000.00	4,339,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,578,000.00	4,339,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,578,000.00	4,339,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,578,000.00	4,339,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	179,824,051.26	282,269,176.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	128,932,551.26	229,449,176.42
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	128,932,551.26	229,449,176.42
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,891,500.00	52,820,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,891,500.00	52,820,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	177,769,525.64	280,468,805.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	177,769,525.64	280,468,805.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	160,213,403.20	249,169,976.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,837,074.17	163,955,736.06
210101	Үндсэн цалин	70,576,866.44	101,719,915.18
210102	Нэмэгдэл	15,037,217.78	45,017,262.88
210104	Урамшуулал	11,222,989.95	17,218,558.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,065,768.72	19,659,653.20
210201	Тэтгэврийн даатгал	8,047,768.72	13,230,653.20
210202	Тэтгэмжийн даатгал	1,004,500.00	1,624,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	803,700.00	758,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	200,800.00	749,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,009,000.00	3,296,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,708,677.56	44,940,838.80
210301	Гэрэл, цахилгаан	1,030,884.56	1,210,902.80
210302	Түлш, халаалт	30,889,145.00	41,691,207.00
210303	Цэвэр, бохир ус	3,788,648.00	2,038,729.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,520,982.75	4,564,898.51
210401	Бичиг хэрэг	537,200.00	1,173,300.00
210402	Тээвэр, шатахуун	997,250.00	1,628,675.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	371,532.75	304,623.51
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	465,000.00	1,098,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,290,900.00	3,978,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		286,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	0.00
210604	Урсгал засвар	6,190,900.00	3,691,750.00
2107	Томилолт, зочны зардал	64,000.00	1,964,000.00
210702	Дотоод албан томилолт	64,000.00	1,964,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,975,000.00	9,456,200.00



210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,275,000.00	9,126,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	520,000.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	751,000.00	650,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	751,000.00	650,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,556,122.44	31,298,828.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,864,200.00	2,043,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,943,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,634,200.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,230,000.00	100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,691,922.44	29,255,828.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,691,922.44	29,255,828.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,632,525.62	6,139,370.93
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,126,900.00	13,096,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,126,900.00	13,096,800.00
225106	Дотоод эх үүсвэрээр	4,126,900.00	13,096,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,126,900.00)	(13,096,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,505,625.62	(6,957,429.07)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,451,803.45	6,957,429.07
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,957,429.07	0.00



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны НИИТ дүн
C01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	76,624,415.82	280,617,204.41	(37,292,272.18)	-	319,949,348.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн			43,133,921.82		43,133,921.82
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	76,624,415.82	280,617,204.41	5,841,649.64	-	363,083,269.87
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	76,624,415.82	280,617,204.41	5,841,649.64	-	363,083,269.87
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
D08	Тайлант үеийн үр дүн			57,998,715.06		57,998,715.06
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	76,624,415.82	280,617,204.41	63,840,364.70	-	421,081,984.93



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	287,269,100.00	264,309,776.57	22,959,323.43	92.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,269,100.00	264,309,776.57	22,959,323.43	92.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	284,546,100.00	262,266,776.57	22,279,323.43	92.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,064,400.00	163,955,736.06	11,108,663.94	93.65
210101	Үндсэн цалин	103,844,100.00	101,719,915.18	2,124,184.82	97.95
210102	Нэмэгдэл	55,305,600.00	45,017,262.88	10,288,337.12	81.4
210104	Урамшуулал	15,914,700.00	17,218,558.00	-1,303,858.00	108.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,695,500.00	19,659,653.20	2,035,846.80	90.62
210201	Тэтгэврийн даатгал	14,753,000.00	13,230,653.20	1,522,346.80	89.68
210202	Тэтгэмжийн даатгал	1,735,700.00	1,624,200.00	111,500.00	93.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	867,800.00	758,500.00	109,300.00	87.4
210204	Ажилгүйдлийн даатгал	867,800.00	749,900.00	117,900.00	86.41
210205	Эрүүл мэндийн даатгал	3,471,200.00	3,296,400.00	174,800.00	94.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,820,000.00	44,940,838.80	879,161.20	98.08
210301	Гэрэл, цахилгаан	1,639,000.00	1,210,902.80	428,097.20	73.88
210302	Түлш, халаалт	41,702,000.00	41,691,207.00	10,793.00	99.97
210303	Цэвэр, бохир ус	2,479,000.00	2,038,729.00	440,271.00	82.24
2104	Хангамж, бараа материалын зардал	6,600,000.00	5,564,898.51	1,035,101.49	84.32
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,173,300.00	-173,300.00	117.33
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,628,675.00	-128,675.00	108.58
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	304,623.51	1,195,376.49	20.31
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	1,000,000.00		100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	360,000.00	140,000.00	72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,100,000.00	1,098,300.00	1,700.00	99.85
2105	Нормативт зардал	500,000.00		500,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00		500,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,181,200.00	15,525,450.00	1,655,750.00	90.36
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,181,200.00	9,217,900.00	963,300.00	90.54
210604	Урсгал засвар	7,000,000.00	6,307,550.00	692,450.00	90.11
2107	Томилолт, зочны зардал	2,300,000.00	1,964,000.00	336,000.00	85.39
210702	Дотоод албан томилолт	2,300,000.00	1,964,000.00	336,000.00	85.39
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,385,000.00	9,456,200.00	3,928,800.00	70.65

ХТ 05438 @ 0422039

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,885,900.00	9,126,200.00	1,759,700.00	83.84
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00		100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,320,000.00	180,000.00	2,140,000.00	7.76
210807	Газрын төлбөр	29,100.00		29,100.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,200,000.00	800,000.00	60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,200,000.00	800,000.00	60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,723,000.00	2,043,000.00	680,000.00	75.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,723,000.00	2,043,000.00	680,000.00	75.03
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,943,000.00	1,943,000.00		100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	100,000.00	680,000.00	12.82
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох				
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг				
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
	Дотоод эх үүсвэрээр				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	287,269,100.00	257,352,347.50	29,916,752.50	89.59
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	229,449,100.00	201,893,958.70	27,555,141.30	87.99
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	229,449,100.00	201,893,958.70	27,555,141.30	87.99
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,820,000.00	51,119,388.80	1,700,611.20	96.78
132001	Орон нутгийн төсвөөс	52,820,000.00	51,119,388.80	1,700,611.20	96.78
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	4,339,000.00	(661,000.00)	86.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	4,339,000.00	(661,000.00)	86.78
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,957,429.07		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
001	Төсвийн бусад мэдээллийн ангилал				
002	Байгууллагын тоо				
005	Ажиллагсдын тоо	6.00	6.00		100.00
006	Удирдах ажилтан	1.00	1.00		100.00
007	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00		100.00
008	Үйлчлэх ажилтан	1.00	1.00		100.00
009	Гэрээт ажилтан	1.00	1.00		100.00
024	Орон тооны мэдээлэл				



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төр засгаас явуулж байгаа соёлын бодлогын гол чиглэл урлагийн мөн чанарыг иргэддээ зөв ойлгуулж өв уламжлалаа хадгалан хамгаалах эзэмшүүлэх өвлүүлэх, орчин цагийн урлагийн төрөл хэлбэрүүдийг өөрсдөө сонгон суралцах зөв боломжийг нээн өгч шинэ шатанд гаргаж хүний хөгжилд дэмждэг үзүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Журам батлах тухай” 2024 оны 128 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” зэрэг хууль эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Соёлын яамны боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж багаа бөгөөд санхүүгийн тайланг холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцүүлэн бэлтгэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Хонгор сумын Соёлын төв нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,998.7 мянган төгрөг болж 15.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,957.4	0.00	0.00
Авлага	528.7	0.00	0.00
Бараа материал	34,822.9	48,927.6	14,104.70
Үндсэн хөрөнгө	320,774.2	372,154.2	51,380.00
Нийт хөрөнгө	363,083.2	421,081.9	57,998.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	76,624.4	76,624.4	
Хуримтлагдсан үр дүн	5,841.6	5,841.6	
Тайлант үеийн үр дүн		57,998.7	57,998.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	280,617.2	280,617.2	
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	363,083.2	421,081.9	57,998.7

Бараа материалын дансны үлдэгдэл 48,927.6 мянган төгрөг болж өмнөх оноос 14,104.70 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангаар Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 19 дугаар тогтоолоор 10.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал үнэ төлбөргүйгээр хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 23,885.6 мянган төгрөгийн материал худалдан авч, тайлант оны үйл ажиллагаандаа 9,780.8 мянган төгрөгийг зарцуулсан зэргээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 372,154.2 мянган төгрөг болж 51,380.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 13,096.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, ОНХС-аас 10,000.0 мянган төгрөгийн ном хэвлэл, Дархан уул аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01-А/314 тоот захирамжаар 25,379.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, мөн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 01-А/491 тоот захирамжаар 3,935.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/16 тоот албан бичгийг үндэслэн 12,790.3 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, дахин үнэлгээгээр 7,519.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус бүртгэж, 54,129.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 421,081.9 мянган төгрөг болж 57,998.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 217,273.3 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

2024 оны батлагдсан төсвийг улсын төсвөөс 353,163.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 69,059.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 14,833.5 мянган төгрөг буюу нийт 437,056.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхдээ 229,449.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 52,820.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг өөрийн орлогоор бүрдүүлэхээр тодотгожээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 229,449.2 мянган төгрөг, үйл ажиллагааны өөрийн орлогоос 4,339.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 52,820.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл 6,957.4 мянган төгрөг буюу нийт 293,565.6 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэлээр 264,309.8 мянган төгрөгийг зарцуулж, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 29,255.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 264,309.8 мянган төгрөг буюу 92.01 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 29,255.8 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702-Соёл урлаг У.төсөв				
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	210,716.10	191,502.76	(19,213.34)	90.88
1.2	80214-Уран бүтээл хийлгэх	5,000.00	4,825.20	(174.80)	96.50
1.3	81855-Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	12,953.00	11,966.21	(986.79)	92.38
1.4	80802-Ажил олгогчоос тэтгэмж урамшуулал	780.00		(780.00)	-
1.5	83603-Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	5,000.00	3,948.23	(1,051.77)	78.96
	120041-Бусад орлого		819.00	819.00	
2	71702-Соёл урлаг О.Н төсөв			-	
2.1	80111-Төрийн өмчийн тогтмол зардал	52,820.00	51,248.40	(1,571.60)	97.02
	Нийт дүн	287,269.10	264,309.80	(22,959.30)	92.01

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д "Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус байгууллага нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 5 ажилтан, үйлчлэх 1 ажилтан буюу нийт 7 ажилтантайгаар ажиллаж, 210801-Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 9,126.2 мянган төгрөг, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 1,200.0 мянган төгрөгийг зарцуулж, Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын соёлын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ахмадын сантай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр, гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 191,031.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,910.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар алдаа, зөрчил гараагүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус төвд 1,399.8 мянган төгрөгийн 2 ширхэг принтер ашиглагдахгүй илүүдэлтэй байна.

Иймд хөрөнгөтэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж шийдэл гаргах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 675.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 675.6 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт Тус байгууллагын нягтлан бодогч цалин, ээлжийн амралтыг 675.6 мянган төгрөгөөр давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн азт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Тайлангийн 4.4.2-т дурдсан Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын нягтлан бодогч цалин, ээлжийн амралтыг 675.6 мянган төгрөгөөр давхардуулан олгосон	1	675.6	1	675.6	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1	675.6	1	675.6	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус байгууллагын Ахмадын тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	
Дүн	1	-	-	-	-	-	1	